



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 30 (555)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай*
- *Оюутны спортын II их наадам зохион байгуулах тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2008 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2008 оны наймдугаар сарын 14

№30 (555)

## Гарчиг

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

473.	Журам батлах тухай	Дугаар 190	886
474.	Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай	Дугаар 191	888
475.	Журам батлах тухай	Дугаар 194	891
476.	Журам батлах тухай	Дугаар 195	894
477.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 196	895
478.	Оюутны спортын II их наадам зохион байгуулах тухай	Дугаар 197	898
479.	Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 198	899
480.	Журам батлах тухай	Дугаар 199	899
481.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 204	902
482.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 205	903
483.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 206	903
484.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 207	903
485.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 208	903
486.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 209	904
487.	Ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 210	904
488.	Ажилд томилох тухай	Дугаар 211	904
489.	Ажилд томилох тухай	Дугаар 213	904
490.	Ажилд томилох тухай	Дугаар 214	905
491.	Ажилд томилох тухай	Дугаар 215	905
492.	Ажилд томилох тухай	Дугаар 216	905
493.	Ажилд томилох тухай	Дугаар 217	905
494.	Ажилд томилох тухай	Дугаар 218	906
495.	Ажилд томилох тухай	Дугаар 219	906
496.	Ажилд томилох тухай	Дугаар 220	906
497.	Ажилд томилох тухай	Дугаар 221	906
498.	Ажилд томилох тухай	Дугаар 222	907
499.	Ажилд томилох тухай	Дугаар 228	907
500.	Ажилд томилох тухай	Дугаар 229	907
501.	Ажилд томилох тухай	Дугаар 230	907
502.	Ажилд томилох тухай	Дугаар 242	908
503.	Ажилд томилох тухай	Дугаар 262	908
504.	Ажилд томилох тухай	Дугаар 271	908

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 7.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ургамлын хорио цээр тогтоосон үед баримтлах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд,

Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД**

**Ц.ГАНХУЯГ**

Засгийн газрын 2008 оны 190 дүгээр тогтоолын хавсралт

### УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭР ТОГТООСОН ҮЕД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь бэлчээрийн болон таримал ургамлын хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарахад тэвигдах шаардлага, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөл, аргыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2. Засгийн газар бэлчээрийн болон таримал ургамал хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн бүс нутгийн хэмжээнд ургамлын хорио цээр тогтоож, цуцална. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрвэл орон нутгийн мэргэжлийн болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоож цуцална.

3. Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрч нутаг дэвсгэртээ ургамлын хорио цээр тогтоосон тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нийтэд зарлан мэдээлж, уг нутаг дэвсгэрт орох, гарах гарцыг тогтоон, тухайн орон нутгийн цагдаагийн болон онцгой байдлын байгууллагатай хамтран хорио цээрийн дэглэм сахиулах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

4. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ургамлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн шатны Засаг даргатай хамтран дараахь арга хэмжээг зохион байгуулна:

4.2. Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчинг оношлох, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны төрөл, зүйлийг тодорхойлох;

4.3. Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны голомтыг тодорхойлох;

4.4. Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтныг устгах.

4.5. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэр, ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтан байгаа байгууламжид ариутгал, халдваргүйжүүлэлт хийх;

4.6. Хорио цээр тогтоосон үед авах арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, хүн хүч, техник хэрэгсэл, материалын тооцоог холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж шийдвэрлүүлэх.

5. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амьн нийгмийн болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, хүнс, барааны хангамжийг тухайн нутаг дэвсгэрийн холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тухайн шатны Засаг дарга зохион байгуулна.

6. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Цагдаагийн байгууллага авч хэрэгжүүлнэ.

7. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн эзэмшлийн газарт ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтан илэрсэн тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон мэргэжлийн байгууллагад мэдэгдэж,

4.1. Ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны тархалтыг тогтоох.

урьдчилан сэргийлэх, устгах арга хэмжээг авахуулна.

8. Энэхүү журмыг тухайн нутаг дэвсгэрт байгаа Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө.

Хоёр. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарахад тавигдах шаардлага

9. Тухайн шатны Засаг дарга онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрийн зааг, уг бүсэд гаднаас орох, гарах цэг, дамжин өнгөрөх зурвасын чиглэлүүдийг тогтоож, анхааруулсан тэмдэг тэмдэглэл тавьж, харуул хамгаалалт ажиллуулна.

10. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах болон дамжин өнгөрүүлэх зурвас дээр шалган нэвтрүүлэх, ариутгал халдваргүйжүүлэлт хийх цэгүүдийг байгуулж, хүний болон машин техникийн хөдөлгөөнийг хянаж зохицуулна.

11. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа олон улсын болон улсын чанартай төмөр зам, авто замын хөдөлгөөн, нисэх буудлын үйл ажиллагааг хяналтад авч, ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн нөхцөлд хүн болон тээврийн хэрэгслийг нэвтрүүлнэ.

12. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөх зөвшөөрөлтэй иргэн, тээврийн хэрэгслийг зөвхөн тогтоосон орох, гарах цэг, дамжин өнгөрөх зурвасаар нэвтрэхийг зөвшөөрнө. Эдгээр цэгүүдэд мэргэжлийн хяналтын байгууллагын хяналтын дор ариутгал, халдваргүйжүүлэлт хийнэ.

13. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт орох, гарах, дамжин өнгөрөх зөвшөөрлийг дор дурдсан тохиолдолд олгоно:

13.1. Хүн эмнэлгийн яаралтай тусламж авах;

13.2. Хүн амыг хоол хүнс болон бусад хэрэгцээт зүйлсээр хангах;

13.3. Албан болон хувь хүний хувьд хойшлуулшгүй ажил гарсан нөхцөлд;

13.4. Олон улсын болон улсын чанартай төмөр зам, авто зам, нисэх буудлаар дайран гарах;

13.5. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа мэргэжлийн багд албан ажлын шаардлага гарсан.

Гурав. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх нөхцөл, арга

14. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт ажиллаж байгаа мэргэжлийн баг нь ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтны биологийн онцлогт тохируулан мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, технологийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, голомтыг устган, цаашид тархах явдлыг таслан зогсооно.

15. Ариутгал, халдваргүйжүүлэлт болон голомтыг устгах үйл ажиллагааг дараахь байгууламж, талбай, тээврийн хэрэгсэлд хийнэ:

15.1. Голомт бүхий талбай;

15.2. Тээврийн хэрэгсэл;

15.3. Ургамал байсан барилга байгууламж, агуулах, зоорь, хүлэмж, ил талбай, үтрэм, бусад зориулалтын хэрэгсэл;

15.4. Голомтод орсон хүний хувцас, хэрэгсэл;

15.5. Бусад халдваргүйжүүлэлт хийх шаардлагатай эд зүйлс.

16. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, голомтыг устгах ажлыг тухайн илэрсэн зүйлийн биологи, нөхцөл байдалд зохицуулан дараахь нийтлэг аргуудаас сонгож хэрэглэнэ:

16.1. Химийн арга: ургамал хамгаалах, ариутгал, халдваргүйжүүлэлт хийх зориулалтын шингэн болон хуурай бодисыг ашиглан тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, ил талбайг шүрших, цацах, барилга байгууламжийн дотоод талыг утах;

16.2. Физикийн арга: зориулалтын техник, төхөөрөмжийг ашиглан битүү тээврийн хэрэгсэл, барилга, байгууламжийг халаах, хөлдөөх;

16.3. Механик арга: илэрсэн зүйлийг цуглуулж цэвэрлэх, шатаах, нүхэнд булах, голомттой талбайн ургацыг нь хурааж устгах.

17. Илэрсэн ургамлын гадаад, дотоод хорио цээртэй өвчин, хог ургамал, хөнөөлт шавж, мэрэгч амьтантай тэмцэхдээ тархалтыг гаднаас нь дотогш хумих буюу голомтын захаас төв рүү чиглэсэн байдлаар ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, голомтыг устгана.

18. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, голомтыг устгахад ашиглах бодис, уусмалын хэмжээ, тун, хугацаа, хэрэглэх аргыг зааврын дагуу чанд мөрдөж ажиллана.



19. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байгаа хүн бүрт аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангана.

20. Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх, голомтыг устгахад ашигласан химийн бодисын үлдэгдэл, сав, баглаа, боодол, хөдөлмөр хамгааллын хувцсыг устгана.

21. Устгал хийх байр, талбайг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийг үндэслэн тухайн шатны Засаг дарга тогтооно.

Дөрөв. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт хориглох зүйл

22. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт дор дурдсан үйл ажиллагааг мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэхгүйгээр явуулахыг хориглоно:

22.1. Бэлчээр, нутаг сэлгэх, нүүх;

22.2. Үр, суулгац тариалах, ургац хураах, борлуулах;

22.3. Хадлан бэлтгэх;

22.4. Явган болон ердийн хөсгөөр хориотой бүсээс гадагш зорчих;

22.5. Халдварын голомт бүхий агуулах, зоорь, сав баглаа, боодол, үйлдвэрийн байр, тоног төхөөрөмж, түүхий эд, хөрс, бэлчээр, талбайг ашиглах;

22.6. Хорио цээр, хязгаарлалт тогтоосон нутаг дэвсгэрээс тээврийн хэрэгслээр тайван бүс нутаг руу зорчих, тээвэр хийх;

22.7. Үзэсгэлэн, хурал, цуглаан, баяр наадам зэрэг нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах;

22.8. Онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс гарах, орох, дамжин өнгөрөх.

Тав. Хариуцлага

23. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Ургамал хамгааллын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

### Үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2008 оны 5 дугаар сарын 9, 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан үйлдвэрлэл эрхлэгчдийн анхдугаар зөвлөгөөнөөс гаргасан зөвлөмж, уриалгыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Бизнесийн орчныг сайжруулах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтын ёсоор баталсугай.

2. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр дор дурдсан арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүүд үүрэг болгосугай:

а) үндэсний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх замаар нийгмийн тогтвортой хөгжилд бүх

нийтийн оролцоог хангах зорилгоор үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнийг 4 жил тутам зохион байгуулж байх;

б) үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх, тэдний туршлагыг харилцан солилцуулах, үндэсний үйлдвэрлэлийн хөгжлийг олон нийтэд сурталчлах зорилгоор "Монголд үйлдвэрлэл" үзэсгэлэн, худалдааг жил бүр зохион байгуулж, тухайн жилийн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж байх.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД

Х.НАРАНХҮҮ

**БИЗНЕСИЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах үндсэн яам, газар	Хамтран оролцох яам, газар
1	Банк, санхүү, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах	1.1. Үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, эзэллийн шинэ бүтээгдэхүүн бий болгон хэрэгжүүлэх, үйлдвэрлэл, технологийн хөгжил, шинэчлэлтийг дэмжих зорилго бүхий төрийн өмчийн оролцоотой хөгжлийн банк байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх 1.2. "Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2007 оны 52 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах 1.3. Үйлдвэрлэл өндөр хөгжсөн орнуудтай хамтран ажиллах, жижиг, дунд үйлдвэрийг санхүүжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын шинэ эх үүсвэр бий болгох асуудлыг судалж хэрэгжүүлэх 1.4. Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг лизингээр олгож эхлэх 1.5. Төрийн оролцоо бүхий технологи дамжуулах төвүүдийг байгуулах ажлыг зохион байгуулах 1.6. Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн урт хугацаатай, бага хүүтэй зээлийн тааламжтай нөхцлийг бий болгох 1.7. Хөрөнгө оруулалт, хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа зээлийн эх үүсвэр, зээл олголтын хүргэмжийг нэмэгдүүлэх 1.8. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг бүрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ авах 2.1. Үндэсний үйлдвэрлэгчдийн санхүүгийн боломж, чарамхийг нэмэгдүүлэх зорилгоор Зээлийн баталгааны сангийн талаар хуулийн төсөл боловсруулах 2.2. Үйлдвэрлэлийн технологийн шинэчлэл, хөгжлийг дэмжих, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Технологи дамжуулах тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт хийх 2.3. Үйлдвэрлэл, технологийн паркын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх 2.4. Түүхий эдийн биржийн талаар хуулийн төсөл боловсруулах 2.5 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх	2008-2009  2008-2012  2008-2012  2008  2008  2009  2009  2009	СЯ, ҮХЯ  ҮХЯ, СЯ, ГХЯ  ҮХЯ, СЯ Монгол банк ҮХЯ, СЯ Монгол банк  СЯ, ҮХЯ  СЯ, ҮХЯ  СЯ, ҮХЯ	Монгол банк                 Арилжааны банк Арилжааны банк Арилжааны банк Арилжааны банк Арилжааны банк
2	Үйлдвэрлэл, бизнесийн эрх зүйн орчныг сайжруулах	2.1. Үндэсний үйлдвэрлэгчдийн санхүүгийн боломж, чарамхийг нэмэгдүүлэх зорилгоор Зээлийн баталгааны сангийн талаар хуулийн төсөл боловсруулах 2.2. Үйлдвэрлэлийн технологийн шинэчлэл, хөгжлийг дэмжих, аюулгүй байдлыг хангах чиглэлээр Технологи дамжуулах тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт хийх 2.3. Үйлдвэрлэл, технологийн паркын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх 2.4. Түүхий эдийн биржийн талаар хуулийн төсөл боловсруулах 2.5 Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх	2009  2009  2009	ҮХЯ, ХЗДХЯ СЯ  ҮХЯ, ХЗДХЯ БСШУЯ  Ажлын хэсэг ҮХЯ, ХХААЯ ХЗДХЯ	ҮХЯ                 Гадаадын хөрөнгө оруулалтын газар

	<p>2.6. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд үндэсний үйлдвэрлэлчдийг бодитой дэмжсэн зохицуулалтыг бий болгох чиглэлээр төсөл боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх</p> <p>2.7. Аялын цагийн зохицуулалттай холбоотой асуудлаар Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах</p> <p>2.8. Монгол Улсад үйлдвэрлэсэн 7200 нэр төрлийн барааг Европын холбооны зах зээлд татваргүйгээр нэвтрүүлэх хугацааг сунах асуудлыг холбогдох талд тавьж шийдвэрлүүлэх</p> <p>3.1. Төрийн үйлчилгээний хүнд суртал, хяналт шалгалтын давхардал, чирэгдлийг арилгах, зөвшөөрлийн системээс стандард, чанарын шаардлыг хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг баталгаажуулах бүртгэлийн системд шилжүүлэх зохих байгуулалтын арга хэмжээ авч ажиллах</p> <p>3.2. Шинээр ажлын байр бий болгосон, хүн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй шинэ дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн, экспортын хэмжээг нэмэгдүүлсэн, татвар болон нийгмийн өмнө хүлээсэн бусад үүргээ нэр төртэй биелүүлж байгаа аж ахуйн нэгжид урамшуулал үзүүлэх механизм бий болгох асуудлыг судалж хэрэгжүүлэх</p> <p>3.3. Орон нутагт ажиллаж байгаа үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор татварын уян хатан бодлогойг үйлдвэрлэлийн бүтцийн онцлогоос хамааруулан оновчтой тогтоох асуудлыг судалж боловсруулах</p> <p>3.4. Үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийг импортын болон нэмэгдсэн өртгийн татвараас хөнгөлөх асуудлыг судлах, гаалийн үнэлгээний системийн зохистой байдлаар боловсронгуй болгох</p> <p>3.5. Төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх</p> <p>4.1. Монгол Улсын худалдааны Дунд хугацааны үзэл баримтлалын төслийг боловсруулах</p> <p>4.2. Үйлдвэрлэл эрхлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчид бэлтгэх чиглэлээр техникийн боловсрол олгох, мэргэжлийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах</p> <p>4.3. Үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээг хангахуйц дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийг хийх санал боловсруулах</p>	<p>2009</p> <p>2009</p> <p>2008.12.31</p> <p>2008</p> <p>2009</p> <p>2009</p> <p>2009</p> <p>2009</p> <p>2008</p> <p>2008-2010</p> <p>2009-2012</p>	<p>СЯ, ХЗДХЯ, УХЯ</p> <p>НХХЯ болон холбогдох яамд</p> <p>УХЯ, ГХЯ</p> <p>УХЯ, БУХ яамд</p> <p>УХЯ, СЯ, БОЯ</p> <p>СЯ, УХЯ</p> <p>СЯ, УХЯ</p> <p>Холбогдох яамд</p> <p>УХЯ</p> <p>БСШУЯ, УХЯ НХХЯ</p> <p>ЗТАЖЯ, ТЭХЯ БХБЯ</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ, СХЗТ</p> <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ</p> <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ, УТЕГ, УТЕГ</p> <p>Аймаг, нийслэлийн ЗДТГ, УТЕГ, УТЕГ</p> <p>Мэргэжлийн нэгдсэн холбоод ГХЯ</p> <p>Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд</p> <p>Холбогдох яамд</p>
<p>3</p> <p>Бизнес эрхлэгчдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгох</p>				
<p>4</p> <p>Бизнесийн хөгжлийг дэмжих</p>				



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

Засгийн газрын 1998 оны 15 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАЯР**

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД**

**Ж.БАТХУЯГ**

Засгийн газрын 2008 оны 194 дүгээр тогтоолын хавсралт

### ЦЭРГИЙН АЛБЫГ САЙН ДУРЫН ҮНДСЭН ДЭЭР ГЭРЭЭГЭЭР ХААХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын иргэн иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаахад энэ журмыг дагаж мөрдөнө.

2. Цэргийн хугацаат албаны хугацаа нь дуусч байгаа байлдагч, түрүүч болон цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн жинхэнэ албан хаагч зөвшөөрөгдсөн мэргэжлээр сайн дурын үндсэн дээр цэргийн албыг гэрээгээр хааж болно.

3. Зэвсэгт хүчинд цэргийн албыг гэрээгээр хааж байгаа иргэн (цаашид "гэрээт цэргийн албан хаагч" гэнэ)-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн зорлигаар батлагдсан "Цэргийн цол олгох журам"-ын дагуу цэргийн цол олгоно.

Хоёр. Иргэнийг гэрээт цэргийн албанд сонгон авах

4. Гэрээт цэргийн албан хаагчийн алба хаах албан тушаал, цолны зэрэглэл, мэргэжлийн жагсаалтыг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб, тооны дээд хязгаарыг батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн эхний улиралд багтаан тогтооно.

5. Цэргийн жинхэнэ албыг 8 сараас доошгүй хугацаагаар хааж байгаа байлдагч, түрүүч, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн болон Зэвсэгт

хүчинд хэрэгцээтэй мэргэжлээр иргэний их, дээд сургууль төгссөн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн 29 хүртэлх насны Монгол Улсын иргэнийг гэрээт цэргийн албан хаагчаар сайн дурын үндсэн дээр сонгон шалгаруулж авч болно.

6. Гэрээт цэргийн албан хаагчаар сонгон шалгаруулах журмыг Зэвсэгт хүчний жанжин штаб тогтоож мөрдүүлнэ.

7. Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй иргэн аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Цэргийн штаб, алба хааж байгаа цэргийн анги, байгууллагын удирдлагад гэрээт цэргийн албанд сайн дураар элсэх тухай өргөдлөө гаргана.

8. Цэргийн штаб, цэргийн анги, байгууллагын удирдлага сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргагчийг батлагдсан журмын дагуу сонгон шалгаруулалтад оруулж, дүнг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб тус тус хүргүүлнэ.

9. Шалгалтын дүн, боловсролын түвшин, мэргэжил, цэргийн алба хаасан байдал, аймаг, нийслэл (дүүрэг)-ийн Цэргийн штаб, цэргийн анги байгууллагын захирагчийн санал, дүгнэлтийг үндэслэн Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб иргэнийг гэрээт цэргийн алба хаалгах тухай шийдвэр гаргана.

10. Гэрээт цэргийн албанд иргэнийг сонгон шалгаруулж авах хугацааг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб тогтооно.



## Гурав. Гэрээ байгуулах

11. Энэ журмын 9 дүгээр зүйлд заасны дагуу гэрээт цэргийн алба хаагдах шийдвэр гарсан иргэнтэй Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штабын эрх бүхий албан тушаалтан "Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-г байгуулна.

12. "Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-нд дараахь асуудлыг тусгана:

- а) гэрээгээр цэргийн алба хаах хугацаа;
- б) гэрээний хугацаанд ажиллах анги, байгууллага, эрхлэх албан тушаал;
- в) цалин хөлс, нэмэгдлийн хэмжээ, түүнийг хадгалах;
- г) гэрээ байгуулагч талуудын эрх үүрэг;
- д) гэрээ байгуулагч талуудын хүлээх хариуцлага;
- е) гэрээ хүчин төгөлдөр болох хугацаа;
- ё) бусад асуудал.

13. Гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 24 сар байна. Цаашид гэрээт цэргийн албан хаагчийн хүсэлт болон цэргийн анги байгууллагын захирагчийн санал, дүгнэлтийг үндэслэн гэрээг тухайн иргэнийг 31 нас хүртэл сунгаж болно.

14. "Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-г 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгална.

## Дөрөв. Гэрээт цэргийн алба хаах

15. Гэрээт цэргийн албан хаагчийн цэргийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчийн нэгэн адил холбогдох хууль тогтоомж, цэргийн дүрмүүдээр зохицуулна.

16. Гэрээт цэргийн алба хаагчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулж болно.

17. Гэрээт цэргийн албан хаагч нь хугацаат албаны байлдагч, түрүүч нарын нэгэн адил цэргийн ангийн байнгын байрлалд байрлана.

18. Цэргийн ерөнхий бэлтгэл, мэргэжлийн бэлтгэл сургалтын үе, шатыг дуусгасан гэрээт цэргийн албан хаагчийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штабын шийдвэрээр цэргийн ангийн байнгын байрлалаас гадна байрлуулж болно.

19. Гэрээт цэргийн албан хаагч нь "Гэрээт цэргийн албан хаагчийн үнэмлэх"-тэй байна. Үнэмлэх нь тухайн гэрээт цэргийн албан хаагчийн

алба хааж байгаа анги, салбарын дугаар, томилогот албан тушаал, алба хаах хугацааны сунгалт болон бусад шаардлагатай мэдээллийг багтаасан байна.

## Тав. Гэрээт цэргийн албан хаагчийн сургалт

20. Гэрээт цэргийн албан хаагчийг сургах цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб батлан гаргаж мөрдүүлнэ.

21. Гэрээт цэргийн албан хаагчийн сургалтыг гэрээгээр цэргийн алба хааж байгаа хугацаанаас нь хамаарч ялгавартайгаар зохион байгуулах ба сургалт явуулах үечлэлийг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штабын сургалт хариуцсан нэгж тогтооно.

22. Цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалтыг тухайн анги, байгууллага цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх ба зарим мэргэжлээр нэгдсэн сургалт, дадлагыг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб зохион байгуулж явуулна.

23. Гэрээт цэргийн албан хаагчийг цэргийн хэрэгт мэргэших, хос мэргэжил эзэмшихэд нь алба хааж байгаа анги, байгууллага бүх талын дэмжлэг үзүүлнэ.

24. Гэрээт цэргийн албан хаагч нь үндсэн сургалт бэлтгэлээс хөндийрөхгүйгээр үүрэг гүйцэтгэхэд шаардагдах мэдлэг, мэргэжил, боловсрол эзэмших зорилгоор оройн болон зайны сургалтад хамрагдаж болно.

## Зургаа. Гэрээт цэргийн албан хаагчийг томилох, шилжүүлэх

25. "Гэрээт цэргийн алба хаах тухай гэрээ"-г үндэслэн тухайн анги, байгууллагын захирагчийн тушаалаар гэрээт цэргийн алба хаагчийг байлдагч, түрүүчийн албан тушаалд томилно.

26. Гэрээт цэргийн албан хаагчийг орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, ажил, мэргэжлийн шаардлага, аргэрийн гачигдлыг харгалзан гэрээнд өөрчлөлт оруулсны үндсэн дээр Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штабын шийдвэрээр өөр анги, байгууллагад шилжүүлэн томилж болно.

27. Цэрэг татлагаас бусад үед гэрээт цэргийн албан хаагч нь томилогдсон анги байгууллагадаа хүрэлцэн очих, түүнчлэн өөр анги байгууллагад шилжин томилогдох үед тээврийн зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож олгоно.



Долоо. Гэрээт цэргийн албан хаагчийн цалин, бусад хангамж

Ес. Гэрээ цуцлах, цэргийн жинхэнэ албанаас халах

28. Гэрээт цэргийн албан хаагчийн албан тушаалын цалинг Засгийн газрын тогтоосон цалингийн сүлжээг үндэслэн батлан хамгаалах болон хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

38. Гэрээт цэргийн албан хаагчтай байгуулсан гэрээг дараахь тохиолдолд цуцална:

29. Гэрээт цэргийн албан хаагчийн мөнгөн орлого нь үндсэн цалин, цолны цалин, цэргийн мэргэжлийн зэргийн, онцгой нөхцөлийн болон бусад нэмэгдлээс бүрдэнэ.

а) гэрээт цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

б) гэрээний хугацаа дуусч, халагдах өргөдлөө гаргасан;

30. Гэрээт цэргийн албан хаагч нь хувцас, хүнсний болон бусад хангалтыг тогтоосон нормын дагуу эдэлнэ.

в) дөрвөн долоо хоногоос дээш хугацаагаар эмчлүүлэх шаардлагатай болсон;

г) ар гэрийн гачигдлын улмаас гэрээгээ цуцлахаар хүсэлтээ гаргасан;

31. Гэрээт цэргийн албан хаагчийн алба хаасан хугацааг иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно.

д) шүүхээр ял шийтгүүлсэн;

е) хүндэтгэх шалтгаангүйгээр анги, байраа орхин явсан;

32. Гэрээт цэргийн албыг 2 жилээс доошгүй хугацаагаар хаасан цэргийн албан хаагч төрийн болон төрийн бус өмчийн магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежид суралцсан тохиолдолд төрийн сангийн эзэлд эхний ээлжинд хамрагдана.

ж) амралт, чөлөөний хугацааг хүндэтгэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн;

33. Албан үүргээ үлгэр жишээчээр гүйцэтгэн гэрээний хугацаагаа дуусгаж байгаа гэрээт цэргийн албан хаагч цэргийн сургуульд суралцах хүсэлт гаргавал боловсрол, мэргэжил, мэдлэгийн түвшнийг нь харгалзан элсэлтийн шалгалтаас чөлөөлж болно.

з) мэргэжил, ур чадвар, сахилга хариуцлагын хувьд ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, цэргийн дүрмийн болон сахилгын зөрчил удаа дараа гаргасныг нь тухайн анги, байгууллагын захирагч нар тодорхойлон гэрээгээ цуцлах санал тавьсан;

Найм. Гэрээт цэргийн албан хаагчийн амралт, чөлөө

и) орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлтөөр мэргэжлийн дагуу өөр анги, байгууллагад шилжин ажиллах боломжгүйгээ тухайн албан хаагч бичгээр мэдэгдсэн.

34. Гэрээт цэргийн албан хаагч нь анги, байгууллагын захирагчийн тушаалаар ар гэрийн гачигдлын учир 7 хүртэл хоногийн цалинтай, 14 хүртэл хоногийн цалингүй чөлөө жилд нэг удаа ажлын өдрөөр тооцон олгох бөгөөд ээлжийн амралтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу биеэр эдлүүлнэ.

39. Гэрээт цэргийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд олгох тэтгэвэр, тэтгэмжийг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.

35. Гэрээт цэргийн албан хаагчийн ээлжийн амралтаараа орон нутагтаа ирж, очиход шаардагдах тээврийн зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож, түүний алба хааж байгаа анги, байгууллага 2 жилд нэг удаа олгоно.

40. Гэрээт цэргийн албан хаагчтай байгуулсан гэрээг энэ журмын 39 дүгээр зүйлд заасны дагуу цуцалбал уг албан хаагчийг хууль тогтоомжийн дагуу цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр хална.

36. Гэрээт цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж, үйлчилгээг холбогдох хуулиар зохицуулна.

41. Гэрээт цэргийн албан хаагч гэрээнд заасан хугацаанаас өмнө гэрээгээ цуцлах хүсэлт гаргавал материалын зардлаа гэрээний дагуу төлсний дараа халах асуудлыг шийдвэрлэнэ.

37. Гэрээт цэргийн албан хаагчийг баяр, амралтын өдрүүдэд ээлжийн журмаар чөлөөгөөр явуулах асуудлыг цэргийн дүрмээр зохицуулна.

42. Халагдаж байгаа гэрээт цэргийн албан хаагчтай байгуулсан гэрээг дүгнэн, холбогдох тооцоог хийсний дараа нийгмийн даатгалын дэвтэр, бусад баримт бичгийг олгоно.

Арав. Гэрээт цэргийн албан хаагчийн хүлээх хариуцлага

43. Гэрээт цэргийн албан хаагч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу Зэвсэгт хүчний цэргийн албан хаагчийн нэгэн адил сахилгын шийтгэл, хуулийн хариуцлага хүлээнэ.

44. Энэ журмын 39 дүгээр зүйлийн "д, е, ж, з"-д заасан шалтгаанаар гэрээгээ цуцалж байгаа гэрээт цэргийн албан хаагч гэрээнд заасны дагуу материалын зардлаа төлнө.

45. Энэ журмын 40 дүгээр зүйлд заасан шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа алдсан иргэнийг эдэлгээний хугацаа дуусаагүй хувцасны болон хүнсний зардлыг төлөхөөс чөлөөлнө.

Арван нэг. Бусад асуудал

46. Гэрээт цэргийн алба хаасан байлдагч, түрүүчийг өөрийнх нь хүсэлт, цэргийн анги,

байгууллагын захирагчийн саналыг үндэслэн Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу ахлагчийн албанд элсүүлж болно.

47. Гэрээний хугацаа дуусч байгаа гэрээт цэргийн албан хаагч цаашид иргэний их, дээд сургууль, коллежид элсэн суралцах хүсэлт гаргавал, түүнд шалгалтын бэлтгэлийг хангахад нь алба хааж буй анги, байгууллагын удирдлага дэмжлэг үзүүлнэ.

48. Гэрээт цэргийн албан хаагч болон түүний алба хааж байгаа анги, байгууллагын хооронд гарсан маргааныг Зэвсэгт хүчний жанжин штаб, Хил хамгаалах ерөнхий газар, Дотоодын цэргийн штаб тус тусын эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ. Шийдвэрийг эс зөвшөөрвөл талууд гомдлоо шүүхээр шийдвэрлүүлж болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

"Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлогыг батлах тухай" Улсын Их Хурлын 1996 оны 15 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Шилдэг уран бүтээлч шалгаруулах журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Шилдэг уран бүтээлч шалгаруулах журмын дагуу олгох мөнгөн урамшуулалд

шаардагдах хөрөнгийг 2009 оноос эхлэн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Н.БОЛОРМАА

Засгийн газрын 2008 оны 195 дугаар тогтоолын хавсралт

### ШИЛДЭГ УРАН БҮТЭЭЛЧ ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Уран бүтээлийн чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, уран бүтээлчийн билэг авьяасыг үнэлэх, урамшуулах зорилгоор өмчийн хэлбэр харгалзахгүй соёл, урлагийн байгууллагаас оны шилдэг уран бүтээлч шалгаруулахад энэ журмыг мөрдөнө.

1.2. Жил бүр тайз, дэлгэцийн найруулагч, тайз дэлгэцийн жүжигчин, тайз, дэлгэцийн зураач, хөгжимчин, дуучин, бүжигчин мэргэжлээр болон Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5.5-д заасан билэг авьяастан тус бүр нэг хүнийг шалгаруулна.

Хоёр. Шилдэг уран бүтээлчид нэр дэвшүүлэх

2.1. Шилдэг уран бүтээлчид соёл, урлагийн байгууллага, хуулийн этгээд нь нэр дэвшүүлнэ.

2.2. Байгууллага, хуулийн этгээдэд хамаардаггүй энэхүү журмын 1.2-т заасан иргэнийг тухайн орон нутгийн Засаг дарга нэр дэвшүүлж болно.

2.3. Шилдэг уран бүтээлчид нэр дэвшүүлэхэд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

2.3.1. уран бүтээлчийн дэлгэрэнгүй анкет;

2.3.2. эрх бүхий болон мэргэжлийн байгууллагын тодорхойлолт;

2.3.3. уран бүтээлийн жагсаалт;

2.3.4. шилдэг уран бүтээлчид нэр дэвшүүлэх үндэслэл, туурвисан бүтээлүүдийн онцлог, үр дүн, ач холбогдол;

2.3.5. тухайн онд улс болон олон улсын тэмцээнд оролцож амжилт гаргасан бол холбогдох гэрчилгээ, батламжийн хуулбар.

2.4. Нэр дэвшсэн уран бүтээлчийн мэргэжлийн ур чадварыг илэрхийлэн батлах зорилгоор видео, аудио бичлэг, CD, фото зураг, бусад баримт ирүүлж болно.

2.5. Байгууллага нь баримт бичгийг тухайн оны 12 дугаар сарын 25-ны дотор соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2.6. Энэхүү журмын 2.5-д заасан хугацаанаас хоцорч ирсэн баримт бичгийг хүлээн авахгүй.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

3.1. Шилдэг уран бүтээлчийг Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан орон тооны бус зөвлөл (цаашид "зөвлөл" гэнэ) шалгаруулж дүгнэлт гаргана.

3.2. Зөвлөл нь мэргэжлийн уран бүтээлч, найруулагч, соёл, урлаг судлаач, мэргэжлийн сургалтын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.3. Зөвлөл нь нэр дэвшигдсэн уран бүтээлчийг сонгон шалгаруулах ажлыг жил бүрийн 01 дүгээр сарын 31-ний дотор зохион байгуулна.

3.4. Зөвлөл нь нийт гишүүдийн 85-аас доошгүй хувийн бүрэлдэхүүнтэй хуралдаж, олонхийн саналаар шилдэг уран бүтээлчийг шалгаруулах дүгнэлт гаргана.

3.5. Зөвлөлийн гишүүн нь нэр дэвшсэн уран бүтээлчийн мэргэжлийн багш, хамт ажилладаг болон төрөл садангийн хүн нь байвал тухайн чиглэлээр асуудлыг хэлэлцэх, санал хураахад оролцуулахгүй.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг үндэслэн соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шилдэг уран бүтээлчийг шалгаруулсан тухай шийдвэр гаргана.

4.2. Шилдэг уран бүтээлчид батламж, 3.0 (гурван) сая төгрөгийн урамшуулал олгоно.

4.3. Шилдэг уран бүтээлчийг урамшуулах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

4.4. Шилдэг уран бүтээлчийн урамшуулалд олгох нийт хөрөнгийн 9 хувьтай тэнцэх хөрөнгийг уран бүтээлчийг сурталчлах, батламж хэвлүүлэх, зөвлөлийн гишүүдийг урамшуулахад зарцуулна.

4.5. Шилдэг уран бүтээлчийг урамшуулахад зориулсан хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 196

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ч.Сайханбилэг нарт тус тус даалгасугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах

хөрөнгийг улсын төсөвт тусган санхүүжүүлж, гадаадын болон хувийн хэвшлийн байгууллагын санхүүгийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормаа, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## Засгийн газрын 2008 оны 196 дугаар тогтоолын хавсралт

### "МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР II"

Нэг. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол бичиг бол хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын салшгүй нэгэн хэсэг бөгөөд энэхүү бичгийг монголчууд XIII зуунаас хэл аялгуундаа тохируулан хэрэглэж, улам төгөлдөржүүлэн олон зүйл мэдлэг ухааны туурвил бүтээлийг бий болгожээ. Монголын ард түмний соёлын өв болсон монгол бичгийг хадгалан хамгаалж, эзэмшин хэрэглэж, төгс төгөлдөр болгох нь хүн төрөлхтний өмнө монголчуудын хүлээсэн үүрэг мөн.

Монгол бичиг XIII зуунаас эхлэн 1950 он хүртэл монголчуудын 750 гаруй жил хэрэглэсэн албан ёсны бичгийн нэг байв. 1950-иад оноос хойш 50 гаруй жил төрийн албан хэргийг кирилл бичгээр хөтөлж байгаа ч Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, хот, аймаг, дүүрэг, сум, хороодын тамгыг монгол бичгээр үйлдэн хэрэглэх болоод 20 шахам жил боллоо. Энэ нь монгол бичиг төрийн бичгийн үндсэн үүргээ гүйцэтгэсээр байгаагийн нэг бодит баримт юм.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангид 1980-ад оны дунд үеэс монгол бичгийг заах болсон нь түүнийг залуу үед өвлүүлэх нэг алхам болсон бол 1990-ээд оны эхээр Монгол оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөн нь үндэсний бичиг үсгээ дахин сэргээх боломжийг нээсэн билээ. "БНМАУ-д албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах болон түүний бэлтгэл ажлыг хангах тухай" Улсын Бага Хурлын 1991 оны 36 дугаар тогтоол гарч, түүнийг хэрэгжүүлэх өргөн далайцтай ажил зохиогдсон байна. Улсын Их Хурлын 1995 оны 43 дугаар тогтоолоор Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг баталсан байна. Уг хөтөлбөрийг 1995-2005 онд хэрэгжүүлж, дэвшүүлсэн зорилтыг үндсэндээ биелсэн гэж Монгол Улсын Засгийн газар үзсэн болно.

Хүн төрөлхтний соёлын санд монголын ард түмний оруулсан үнэт хувь нэмэр төдийгүй дэлхийн утга, соёлын нандин өв болсон монгол бичгээ хойч үедээ өвлүүлэх нь зүй ёсны хэрэг юм.

Монгол Улсын Засгийн газраас "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2008 оны 19 дүгээр захирамжаар батлагдсан ажлын хэсэг уг хөтөлбөрийг шинэчлэн боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

2.1. Монгол Улсын иргэн бүрт монгол бичгийг сурч, эзэмших боломж нээлттэй байх;

2.2. Улсын Их Хурлын 1994 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 66 дугаар тогтоолын 3 дугаар заалтыг үндэслэн монгол бичгийн сургалтыг суурь боловсролын агуулгад багтаан зохион байгуулж, бүх нийтийг сургах;

2.3. Монгол бичгийн хичээлийг монгол хэлний боловсролын стандарт, монгол хэл, уран зохиолын хичээлийн хөтөлбөрийн үзэл баримтлалтай нягт уялдуулах;

2.4. Монгол бичгийн хөтөлбөр нь "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого", "Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө" зэрэг баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь монголчуудын оюуны соёлын салшгүй бүрэлдэхүүн, давтагдашгүй өв болсон монгол бичгийг иргэдэд эзэмшүүлэх, хойч үедээ өвлүүлэх орчин нөхцөлийг бий болгох, энэ чиглэлийн сургалт, судалгаа, сурталчилгааг шинэ түвшинд гаргах, улмаар бүх нийтийн хэрэглээний бичиг болгоход оршино.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлж байна.

3.1. Монгол бичгийн багшийг бэлтгэх, давтан бэлтгэх;

3.2. Монгол бичгийн сургалтын орчныг сайжруулж, хэрэглээг өргөтгөх;

3.3. Иргэдэд монгол бичгийг албан болон албан бус сургалтаар зааж сургах;

3.4. Монгол бичгийн судалгаа, сурталчилгааны ажлыг өргөжүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.1.1. багш бэлтгэдэг төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуулийн монгол хэлний багш, арга зүйн мэргэжилтэн бэлтгэх ангийн сургалтын төлөвлөгөөнд монгол бичгийн хичээлийн цагийг нэмэгдүүлэн монгол бичиг заах арга зүйг шинээр оруулж, сургалтын чанарыг сайжруулах;

4.1.2. ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн монгол бичгийн багш нарын мэргэшлийг үе шаттайгаар дээшлүүлэх, тэднийг давтан сурах;

4.1.3. ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, хүмүүнлэг, нийгмийн ухааны багш нарын мэргэшлийн түвшинд тавигдах шаардлагад монгол бичиг сурч эзэмшсэн байдлыг нэг үзүүлэлт болгох;

4.1.4. ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа 4.1.3-т зааснаас бусад мэргэжлийн багш болон багш бэлтгэдэг сургуульд өөр мэргэжлээр сурч байгаа оюутнуудын сонирхлыг үндэслэн монгол бичгийн хичээл заах эрх олгох сургалтад хамруулах.

4.2. Хөтөлбөрийн хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.2.1. төрийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд монгол бичгийг хэрэглэж байх;

4.2.2. төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын хаяг, бүтээгдэхүүний шошгыг монгол бичгээр үйлдэхийг дэмжих;

4.2.3. ерөнхий боловсролын сургуулийн монгол бичгийн сурах бичиг, сурагчийн дасгал ажлын дэвтэр, багшийн ном, сургалтын хэрэглэгдэхүүнийг цогцоор нь бэлтгэж хэвлэх;

4.2.4. ерөнхий боловсролын сургуульд монгол бичгийн танхим байгуулах, сургалтад хэрэглэгдэж байгаа компьютерт монгол үсгийн программ суулгаж, түүнийг ашиглаж сурах, хэрэглээ болгох;

4.2.5. монгол бичгийн багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

4.2.6. монгол бичгээр уламжлан ирсэн эртний уран зохиолыг хэвлэн нийтлэхийн зэрэгцээ орчин цагийн уран зохиолыг монгол бичгээр хөрвүүлэн хэвлэх, монгол бичгээр унших нөхцөлийг бүрдүүлэх;

4.2.7. монгол бичгээр хэвлэгдсэн түүх, соёлын бүтээлийг судлах, дахин хэвлэх зэргээр нийтийн хүртээл болгох;

4.2.8. иргэд бие дааж монгол бичиг сурахад зориулж ном, сурах бичиг, гарын авлага, толь бичгийг цаасан болон электрон хэлбэрээр үйлдэж, түгээх ажилд дэмжлэг үзүүлэх;

4.2.9. төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн үүсгэл санаачилгаар зохион байгуулах монгол бичиг сурах, сурталчлахад чиглэсэн санал, санаачилгыг дэмжих.

4.3. Хөтөлбөрийн гуравдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.3.1. ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн болон их, дээд сургуулийн нийгмийн ухаан, хүмүүнлэгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг ангийн сургалтын төлөвлөгөөнд монгол бичгийн хичээлийг оруулж, хэрэгжилтэд Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавих;

4.3.2. монгол бичгийн сургалтын агуулга, арга зүйг нийгмийн ухааны боловсролын стандарт, сургалтын хөтөлбөртэй уялдуулах;

4.3.3. хөтөлбөрийн 4.3.2-т зааснаас бусад чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд монгол бичгийн хичээлийг тусгах;

4.3.4. төрийн болон төрийн бус өмчийн их, дээд сургуульд монгол хэл, уран зохиолын багш, эх бичиг судлаач, сэтгүүлч, түүх, нийгмийн ухаан, аялал жуулчлалын мэргэжлээр элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын монгол хэлний хичээлийн агуулгад монгол бичгийг оруулах;

4.3.5. албан болон албан бус сургалтын олон хэлбэрээр монгол бичиг зааж, иргэдийн монгол бичиг сурах идэвхи сонирхлыг өрнүүлэх.

4.4. Хөтөлбөрийн дөрөв дэх зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

4.4.1. монгол бичгийн заах арга, монгол бичгийн уламжлал шинэчлэлийн судалгааг гүнзгийрүүлэх;

4.4.2. хэвлэл мэдээллийн хэрэгслүүд "Монгол бичгийн сургалтын булан"-г нээж, олон хэлбэрийн үйл ажиллагааг зохион байгуулах;

4.4.2. монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг өргөжүүлж, орчин үеийн мэдээлэл, харилцааны технологийн дэвшилтэй хослуулах;

4.4.3. цахим техникийн орчинд кирилл, монгол бичгийг харилцан хөрвүүлэх программыг боловсруулах судалгааны ажлыг дуусгаж, сургалт, судалгаанд хэрэглэх.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, хяналт

5.1. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг 2008-2015 онд хэрэгжүүлнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэгтэй ажлын хэсгийг Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулна.

5.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүрэгт сум, дүүргийн Засаг дарга ахалж ажиллана.

5.4. Хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг жил бүр Засгийн газарт тайлагнана.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II"-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж хэрэгжилтэд боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

6.2. Хөтөлбөрийн холбогдох заалтыг төсвийн ерөнхийлөн захирагчаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

6.3. Гадаад орон, олон улсын хандивлагч байгууллагын болон иргэд, төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэг авах нөхцөлийг бүрдүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн шалгуур, үзүүлэлт

Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур, үзүүлэлтээр дүгнэнэ:

7.1. Монгол бичгийг заах үр чадвар сайтай багш бэлтгэгдсэн байна,

7.2. Монгол бичгийн багш нарын заах арга зүй сайжирсан байна;

7.3. Төрийн захиргааны болон хэвлэл мэдээллийн байгууллагад монгол бичгийн орчин, хэрэглээ бүрдсэн байна;

7.4. Монгол бичиг сурах иргэдийн сонирхол, хэрэгцээ өссөн байна;

7.5. Иргэдийн монгол бичгийн мэдлэг, чадварын түвшин ахисан байна;

7.6. Бүх шатны монгол бичгийн сургалтын чанар дээшилсэн байна.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг үндэслэн хөтөлбөрийн хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, мөрдүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Оюутны спортын II их наадам зохион байгуулах тухай

Биений тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

соёл, шинжлэх ухааны сайд Н.Болормaa, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасуяй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

Б.БАТСЭРЭЭДЭНЭ

Оюутны спортын II их наадмыг 2009 онд хамтран зохион байгуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Боловсрол,

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

### Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 18 дугаар хавсралтаар баталсан Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнд дор дурдсан өөрчлөлт оруулсугай:

1. "Гишүүд" гэсэн хэсгийн "Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Баттөр" гэсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн Нийгмийн бодлогын зөвлөх Л.Лхагва (зөвшилцсөнөөр) гэж нэмсүгэй.

2. Мөн хэсгийн "Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн ёслол, үйлчилгээний салбар хорооны дарга Х.Бэхбат" гэснийг "Гадаад хэргийн дэд сайд, Төрийн ёслол, хүндэтгэлийн салбар хорооны дарга Б.Энхмандах" гэж, "Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга М.Ганболд" гэснийг "Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд дарга, Хэв журмын салбар хорооны дарга Ч.Амарболд" гэж, "Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Ц.Уугангэрэл" гэснийг "Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Л.Батзориг" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**С.БАЯР**
**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**
**М.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 05 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Улсын нөөцийн тухай хуулийн 13.1.8, 13.1.9-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Гамшгийн нөөцөөс бараа, материал захиран зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам"-ыг 1 дүгээр, "Нөөцийн бараа, материалыг хүлээн авах, хадгалах, шинэчлэх, хэвийн хорогдол тооцох журам"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт

тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболдод үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 57 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**С.БАЯР**
**МОНГОЛ УЛСЫН  
ШАДАР САЙД**
**М.ЭНХБОЛД**

Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## ГАМШГИЙН НӨӨЦӨӨС БАРАА, МАТЕРИАЛ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, НӨХӨН БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Гамшгийн нөөцөөс бараа, материалыг захиран зарцуулах

1.1. Улсын нөөцийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу гамшгийн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, захиран зарцуулах, санхүүжүүлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллага энэхүү журмыг мөрдөж ажиллана.

2.1. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход зориулагдах гамшгийн нөөцийн бараа, материалыг улсын нөөцөөс эргэн төлөгдөх болон эргэн төлөгдөхгүй нөхцөлөөр гаргах шийдвэрийг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.



2.2. Засгийн газрын шийдвэрийн дагуу гамшгийн нөөцийн барааг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон тохиолдолд онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага зээлдэгчтэй гэрээ байгуулна. Гэрээнд бараа, материалын чанар, стандарт, нэр төрлийн тоо хэмжээ, үнэ, нөхөн бүрдүүлэх хугацаа, хүлээх хариуцлагын талаар тусгасан байна. Шаардлагатай бол тухайн барааны үнийн дүнтэй дүйцэх хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны баталгааг гаргуулж авна.

2.3. Гамшгийн нөөцөөс бараа, материал гаргах асуудлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлийг үндэслэн улсын нөөцийн салбарууд хэрэгжүүлнэ.

2.4. Гамшгийн нөөцөөс бараа, материал олгох тухай зээлдэгчтэй байгуулах гэрээ болон зөвшөөрлийн үлгэрчилсэн загварыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

Гурав. Гамшгийн нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэх

3.1. Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллага гамшгийн үеийн бэлэн байдлын зэрэгт тулгуурлан гамшгийн нөөцөд байх бараа, материалын байршил, нэр төрөл, тоо хэмжээг шинэчлэн боловсруулж Засгийн газраар батлуулах бөгөөд санхүүжилтийн асуудлыг жил бүр санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулана.

3.2. Улсын төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх гамшгийн нөөцийн бараа, материалыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас баталсан нэр төрөл, тоо хэмжээгээр улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллага дээр бүрдүүлэх ажлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

3.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас зарцуулсан гамшгийн нөөцийн бараа, материалыг нөхөн бүрдүүлэхдээ харьцуулалтын аргаар болон шууд гэрээ байгуулах байдлаар бүрдүүлж болно.

3.4. Гамшгийн нөөцийн бараа, материалын хугацааг харгалзан шинэчлэх, хадгалалтын технологи, сав баглаа боодлыг сайжруулах зорилгоор бараа, материалын 20 хүртэлх хувийг улирал тутам борлуулж, тухайн барааны тоо хэмжээ, чанарыг бууруулалгүйгээр нөхөн бүрдүүлэх асуудлыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Дөрөв. Гамшгийн нөөцийн санхүүжилт, тайлан бүртгэл

4.1. Улсын нөөцийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу гамшгийн нөөцийн бараа, материалыг бүрдүүлэх, зарцуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

4.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дээрх зардлын санхүүжилтийн тооцоог боловсруулан жил бүр төсвийн хүрээний мэдэгдлийн санал, төсвийн төслийн хамт санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3. Батлагдсан төсвийн дагуу нөөцийн бараа, материалыг шинээр бүрдүүлэх, худалдан авсан төлбөрийг хийхдээ дараахь материалыг бүрдүүлнэ:

4.3.1. тендерийн материал;

4.3.2. гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хувь;

4.3.3. санхүүгийн анхан шатны баримт (нэхэмжлэх, зарлагын баримт, орлогын баримт);

4.3.4. бараа, материалыг хүлээлцсэн нотломж;

4.3.5. холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт.

4.4. Нөөцийн бараа, материалыг шинэчлэхэд гарсан зардлыг санхүүжүүлэхэд дараахь материалыг бүрдүүлнэ:

4.4.1. нөөцийн барааг шинэчлэх тухай онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлагын шийдвэр;

4.4.2. тендерийн материал (худалдан авах, шинэчлэх гэрээ);

4.4.3. санхүүгийн анхан шатны баримт (нэхэмжлэх, зарлагын баримт, орлогын баримт);

4.4.4. холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт.

4.5. Нөөцийн бараа, материалыг сэлгэх, тээвэрлэн байршуулах, хадгалах, хэвийн хорондлыг нөхөхтэй холбогдон гарсан зардлыг санхүүжүүлэхдээ дараахь материалыг бүрдүүлнэ:

4.5.1. тээвэрлэн байршуулах гэрээ, сэлгэлт хийсэн тухай нотломж;

4.5.2. тухайн салбарт бараа, материалыг хүлээн авсан орлогын баримт;

4.5.3. холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт;

4.5.4. нэхэмжлэх.

4.6. Гэрээт хадгалагчдад гамшгийн нөөцийн бараа, материал хадгалуулсны төлбөрийг хийхдээ дараахь баримтыг үндэслэнэ:

4.6.1. нөөцийн бараа, материалын хадгалагчдын гэрээ;

4.6.2. нэхэмжлэх.

4.7. Даатгалын зардлыг олгохдоо дараахь баримтыг үндэслэнэ:

4.7.1. даатгалын байгууллагатай хийсэн гэрээ, хохирлын тооцоо;

4.7.2. нэхэмжлэх.

4.8. Гамшгийн нөөцөд хүлээн авсан бараа, материалын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, агуулахын засварт зарцуулсан хөрөнө, нөөцийн бараа, материалыг салбар хооронд сэлгэн байршуулахад гарсан тээврийн зардлыг барааны ертөгт нэмж тооцохгүй.

4.9. Гэрээт хадгалагч байгууллага нь гамшгийн нөөцийн барааны хөдөлгөөн, үлдэгдлийн тоо хэмжээг өөрийн мэдлийн эргэлтийн барааны хөдөлгөөн, үлдэгдлийн статистик мэдээнд хамааруулахгүй.

4.10. Улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллага нь гамшгийн нөөцийн бараа,

материалын болон мөнгөн хөрөнгийн хөдөлгөөн, тооллого, барааны хадгалагдсан хугацаа, чанарын талаархи мэдээ тайланг эвхэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад улирал бүрийн эхний сарын 5-ны дотор нууцлан ирүүлж байна.

4.11. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гамшгийн нөөцийн бараа, материалыг зарцуулсан, худалдсан, нөхөн бүрдүүлсэн талаархи мэдээ, тайланг улирал тутамд санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад нууцлан хүргүүлнэ.

## Тав. Хариуцлага

5.1. Улсын нөөцөд бараа, материал нийлүүлэх болон улсын нөөцийн бараа, материалыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох хуулийн этгээд, гэрээт хадгалагчтай байгуулах гэрээнд Улсын нөөцийн тухай хуулийн 18.2-т заасан нөхцөлийг заавал тусгах бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль болон тухайн гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Улсын нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2008 оны 199 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## НӨӨЦИЙН БАРАА, МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ, ХАДГАЛАХ, ШИНЭЧЛЭХ, ХЭВИЙН ХОРОГДОЛ ТООЦОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Стратегийн болон гамшгийн нөөцөд бараа, материалыг хүлээн авах, хадгалах, сэлгэх, шинэчлэхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллага энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Нөөцийн бараа, материалыг хүлээн авах

2.1. Нөөцийн бараа, материал нийлүүлэх хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ, бараа хүлээн авах албан ёсны зөвшөөрөл, чанар, стандартын шаардлага хангасан тухай холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллага нөөцөд барааг хүлээн авна.

2.2. Улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллага нь нийлүүлэгч байгууллагын

зарлагын баримт, мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлтийг барааны чанар байдалтай тулган тоо хэмжээ, жин, баглаа боодлоор хүлээж авах бөгөөд чанар, стандартын зөрүүтэй, тоо хэмжээ болон жиндээ хүрээгүй, сав баглаа нь задарч урагдсан нөхцөлд тухайн бараа, материалыг хүлээн авахгүй.

2.3. Улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллага нь нийлүүлэгч байгууллагаас бараа, материалыг хүлээн авсан тухай акт үйлдэж, анхан шатны баримт, чанарын шинжилгээний дүгнэлтийн хамт онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.4. Улсын нөөцөд хүлээн авах барааны хадгалсан хугацаа нь хадгалах хүчинтэй хугацааны 20 хувиас хэтрээгүй байна.

Гурав. Нөөцийн бараа, материалыг хадгалах

3.1. Нөөцийн бараа, материалыг төвлөрсөн болон төрөлжсөн агуулахад технологийн дагуу

хадгалах бөгөөд агуулахын багтаамж, хадгалалтын технологийн шаардлагаас хамааран зарим барааг хадгалалтын тусгай нөхцөл хангасан аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан хадгална. Гэрээнд Улсын нөөцийн тухай хуулийн 7.2, 18.2-т заасан асуудлыг тусгасан байна.

3.2. Улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллагад хадгалах барааны жагсаалтыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

3.3. Агуулах нь нөөцийн бараа, материалыг технологийн дагуу, хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн эсэх, стандарт, эрүүл ахуй, аюулгүйн шаардлага хангаж байгаа эсэх талаар мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг гаргуулсан байна.

3.4. Улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллага нь улсын нөөцийн бараа, материалыг технологийн горимын дагуу барааны төрөл, үйлдвэрлэсэн болон хүлээн авсан он, чанарыг харгалзан төрөлжүүлэн хурааж, өрж байршуулах бөгөөд тоо хэмжээ, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, төрөл тус бүрд барааны хөдөлгөөний маягтыг хөтөлсөн байна.

3.5. Нөөцийн бараа, материалын чанарын шинжилгээг мэргэжлийн хяналтын байгууллагаар жилд 1-2 удаа хийлгэж улсын байцаагчийн дүгнэлт гаргуулж байна.

3.6. Хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцоходоо улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч байгууллага нь тухайн барааны хэвийн хорогдлыг тооцох журам, зааврыг мөрдөж ажиллана.

Дөрөв. Нөөцийн барааг шинэчлэх, сэлгэх

4.1. Нөөцийн бараа, материалын чанарын талаархи мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, тухайн барааны хадгалах хүчинтэй хугацаа зэргийг харгалзан улсын нөөцийн барааны 20 хүртэлх хувийг улирал тутам борлуулж тоо хэмжээ, чанарыг нь бууруулалгүйгээр тухайн бараагаар нь

эргүүлэн авах нөхцөлтэйгээр улсын нөөцөөс гаргаж шинээр нөхөн бүрдүүлнэ.

4.2. Улсын нөөцийн бараа, материалыг шинэчлэх зорилгоор худалдан борлуулахыг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шийдвэрлэх бөгөөд худалдан авагч этгээдийн төрийн сангийн зохих дансанд толбор хийсэн баримтыг үндэслэн барааг олгоно.

4.3. Нөөцийн барааны хадгалалтын хугацаа, чанар байдлын өөрчлөлт, мэргэжлийн хяналтын байгууллагын шинжилгээний дүгнэлт зэргийг үндэслэн онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга шинэчлэх, сэлгэх барааны нэр төрөл, тоо хэмжээ, хугацааг тодорхой тусгасан хуваарийг тухайн жилийн эхэнд батална.

4.4. Баталсан нөөцийн бараа, материалыг шинэчлэх хуваарийн дагуу барааг улсын нөөцийн салбар, гэрээт хадгалагч байгууллагаас гаргах зөвшөөрлийг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын улсын нөөцийн асуудал хариуцсан нэгжийн дарга олгоно.

4.5. Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас олгосон албан ёсны зөвшөөрлийн дагуу нөөцийн барааг шинэчлэх, сэлгэх үүргийг улсын нөөцийн салбар болон гэрээт хадгалагч гүйцэтгэнэ.

Тав. Хариуцлага

5.1. Улсын нөөцийн барааг нийлүүлэх болон эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох хуулийн этгээд, гэрээт хадгалагчтай байгуулах гэрээнд Улсын нөөцийн тухай хуулийн 18.2-т заасан нөхцөлийг заавал тусгах бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нөхцөлд хууль болон тухайн гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээгэхээргүй бол Улсын нөөцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ямны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Цэвэлсодномын Ганхүү Барилга, хот байгуулалтын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>д</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Чимэдийн Сайханбилэгийг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 206

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>д</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын Хэрэг эрхлэх газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Даваадоржийн Ганболдыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 207

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Жамьянхорлоогийн Сүхбаатарыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 208

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>д</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэрэгжүүлэгч агентлаг-Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Буян-Өлзийгийн Жаргалсайханыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үймчилгээ, аж ахуйн газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Сэнгээгийн Баярмөнхийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Дипломат байгууллагын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

### Ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27.5, Төрийн албаны тухай хуулийн 23.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

агентлаг-Удирдлагын академийн захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон тул гаргасан хүсэлтийг нь харгалзан Тогоочийн Лхагвааг Засгийн газрын хэрэгжүүлэгч

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэрэг эрхлэх газрын дэд даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Даржаагийн Нямжавыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

### Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хэрэгжүүлэгч агентлаг-Ойн хэрэг эрхлэх газрын даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Мажигийн Тунгалагийг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Батбаярын Төмөрхуягийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Дамдины Цогтбаатарыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 216

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Цэрэндоржийн Ганболдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Дипломат байгууллагын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

академийн захирлаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Гэлэгпилийн Чулуунбаатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Удирдлагын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

тосны Хэрэг эрхлэх газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Жанчивийн Билэгсайханыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Ашигт малтмал, газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

холбоо, технологийн газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Жиймэнгийн Сансарыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Мэдээлэл, харилцаа

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хянан зохицуулах газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Дашдоржийн Мандахыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Шударга бус өрсөлдөөнийг

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>3</sup> дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэрэг эрхлэх газрын даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

Төгсөөгийн Батболдыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Н.ЭНХБОЛД



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 222

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17.12-т томилсугай.

заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Шилагарьдийн Солонгоог Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргаар

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Даваахүүгийн Баттөрийг Сангийн яамны

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18<sup>д</sup> дугаар хэрэгжүүлэгч агентлаг-Улсын гаалийн ерөнхий газрын даргаар томилсугай.

зүйлийн 2 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Дэргээгийн Цэвээнжавыг Засгийн газрын

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2008 оны 06 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД С.БАЯР

Түдэвхүүгийн Гантулгыг Байгаль орчны

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХБОЛД